



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Элка ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ОМА-2026/016/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас:70533539 Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Г.Шижирболд  
Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал:  
Г.Энхмаа  
Утас: 77450279 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

---

<b>АГУУЛГА</b>	
<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
<b>2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан</b> .....	<b>5</b>
<b>2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> .....	<b>6</b>
<b>2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</b> .....	<b>7</b>
<b>2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл</b> .....	<b>7</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>9</b>
3.2 АЛБАН ШААРДЛАГА.....	9
3.3 ЗӨВЛӨМЖ.....	9
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>10</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

---

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.08.16 № 318  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХАНХОНГОР СУМЫН ЭЛКА  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Т.ТҮВШИНТӨР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ханхонгор сумын "Элка" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны 434.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны 10.3 сая төгрөг, хандив тусламжийн 126.4 сая төгрөгийн орлогыг хүлээн авч, хуримтлагдсан элэгдлийн 419.3 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч, 45.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант хугацаанд Ханхонгор сумын Засаг даргын захирамжаар хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой 5,850.7 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд

4626050502

Б.12 Бичиг хэрэг 2026 он ЦТА-н дүгнэлт Төсөл Досх

шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
2	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>57,766,116.54</b>	<b>56,915,249.38</b>
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,747,397.08	25,187,108.61
4	Дансны авлага	2,878,737.15	100,987.26
5	Бараа материал	41,225,859.07	31,627,153.51
6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,914,123.24	
7	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>57,766,116.54</b>	<b>56,915,249.38</b>
8	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>6,368,123,916.35</b>	<b>6,021,583,174.81</b>
9	Үндсэн хөрөнгө	6,345,301,333.10	5,998,685,174.81
10	Бусад эргэлтийн бус хөрөнгө	22,822,583.25	22,898,000.00
11	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>6,368,123,916.35</b>	<b>6,021,583,174.81</b>
12	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,425,890,032.89</b>	<b>6,078,498,424.19</b>
13	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
14	<b>Өр төлбөр</b>	<b>6,166,691,992.90</b>	<b>5,865,037,612.33</b>
15	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>2,725,477.00</b>	<b>14,292,725.59</b>
16	Татварын өр		1,618,188.59
17	Нөөц төлбөр/Ахмадын сан/	2,725,477.00	12,674,537.00
18	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,725,477.00</b>	<b>14,292,725.59</b>
19	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
20	Бусад урт хугацаат өглөг	6,163,966,515.90	5,850,744,886.74
21	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>6,163,966,515.90</b>	<b>5,850,744,886.74</b>
22	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>6,166,691,992.90</b>	<b>5,865,037,612.33</b>
23	<b>Эздийн өмч</b>	<b>259,198,039.99</b>	<b>213,460,811.86</b>
24	Өмч: - төрийн	290,724,837.86	290,724,837.86
25	-хувийн	22,498,000.00	22,498,000.00
26	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	66,614,994.46	66,614,994.46
27	Хуримтлагдсан ашиг(алдагдал)	(120,639,792.33)	(166,377,020.46)
28	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>259,198,039.99</b>	<b>213,460,811.86</b>
29	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,425,890,032.89</b>	<b>6,078,498,424.19</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	408,242,064.66	434,035,164.61
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	569,487,273.32	898,311,224.30
3	<b>Нийт ашиг/алдагдал/</b>	<b>(161,245,208.66)</b>	<b>(464,276,059.69)</b>
4	Бусад орлого	227,310,795.54	557,595,650.37
5	Ерөнхий ба удирдлагын зардал	129,810,659.28	137,378,287.78
6	Бусад зардал	1,507,418.02	
7	Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз ( гарз)	33,303,688.14	
8	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал/</b>	<b>(98,556,178.56)</b>	<b>(45,737,228.13)</b>
9	<b>Татварын дараах ашиг алдагдал</b>	<b>(98,556,178.56)</b>	<b>(45,737,228.13)</b>
10	<b>Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/</b>	<b>(98,556,178.56)</b>	<b>(45,737,228.13)</b>
11	Бусад дэлгэрэнгүй орлого		1,678,531.03

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,222,837.86	66,614,994.46	(120,639,792.33)	259,198,039.99
2	2025 оны 01-р сарын 30-нээрх үлдэгдэл	313,222,837.86	66,614,994.46	(120,639,792.33)	259,198,039.99
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(45,737,228.13)	(45,737,228.13)
5	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
6	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,222,837.86	66,614,994.46	(166,377,020.46)	213,460,811.86

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Элка ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>488,306,591.45</b>	<b>623,971,945.63</b>
3	Бусад мөнгөн орлого	488,306,591.45	623,971,945.63
4	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>550,219,484.42</b>	<b>607,067,334.10</b>
5	Ажиллагчдад төлсөн	238,703,661.00	291,520,597.00
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	67,930,954.74	83,520,471.83
7	Бараа материал худалдан авахад төлсөн	46,357,302.66	48,181,565.49
8	Ашиглалтын зардалд төлсөн	33,885,242.02	63,215,584.81
9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	59,225,920.00	53,042,080.00
10	Татварын байгууллагад төлсөн	60,039,304.00	61,837,034.97
11	Бусад мөнгөн зарлага	32,349,850.00	5,750,000.00
12	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(61,912,892.97)</b>	<b>16,904,611.53</b>
13	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
14	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
15	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,727,250.00</b>	<b>464,900.00</b>
16	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(11,727,250.00)</b>	<b>(464,900.00)</b>
17	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
18	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(61,912,928.97)</b>	<b>16,439,711.53</b>
19	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>8,747,397.08</b>
20	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>25,187,108.61</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны Гүйцэтгэл	2025 он		Зөрүү
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>Нийт орлого</b>		<b>651,779.59</b>	<b>971,135.65</b>	<b>991,630.79</b>	<b>20,495.14</b>
<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>386,760.85</b>	<b>408,909.35</b>	<b>434,035.16</b>	<b>25,125.81</b>
а/ Дулааны орлого	мян.төг	370,907.51	398,277.65	413,820.00	15,542.35
б/ Усан хангамж ариутгах татуургын орлого	мян.төг	15,853.34	10,631.70	20,215.16	9,583.46
<b>Үйл ажиллагааны бус орлого</b>		<b>265,018.74</b>	<b>562,226.30</b>	<b>557,595.63</b>	<b>(4,630.67)</b>
Бусад ажлын орлого	мян.төг	19,063.00			-
д/ Хойшлогдсон орлогоор бүртгэгдсэн элэгдлийн орлого	мян.төг	191,236.14	419,251.40	419,251.40	-
е/ Зам талбайн үйлчилгээний орлого	мян.төг	18,644.95	74,174.90	74,174.23	(0.67)
ё/ Нутгийн дэм	мян.төг	32,186.56	68,800.00	63,670.00	(5,130.00)
Шинээр үнэ тогтоосон хөрөнгийн орлого, бусад	мян.төг	3,888.09	-	500.00	500.00
<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>734,109.04</b>	<b>1,118,998.86</b>	<b>1,037,368.00</b>	<b>(81,630.86)</b>
Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	129,810.66	120,680.01	137,378.30	16,698.29
Татварын өмнөх ашиг	мян.төг	-	-	(45,737.21)	(45,737.21)
<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>мян.төг</b>	<b>(82,329.45)</b>	<b>(147,863.21)</b>	<b>(45,737.21)</b>	<b>102,126.00</b>
<b>Төсвийн төлбөр</b>	<b>мян.төг</b>	<b>139,332.30</b>	<b>146,720.59</b>	<b>135,361.59</b>	<b>(11,359.00)</b>
Нэмэгдсэн өртгийн албан татвар	мян.төг	44,044.70	54,993.70	53,760.80	(1,232.90)
Газрын төлбөр	мян.төг	204.90	204.90	204.98	0.08
Агаарын бохирдлын төлбөр	мян.төг	38.00	53.00	53.00	-

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Элка ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	98.60	96.80	96.80	-
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	мян.төг	67,952.50	54,912.29	51,580.45	(3,331.83)
Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	1,386.50	1,386.90	1,331.17	(55.73)
ХХОАТ	мян.төг	25,607.10	35,073.00	28,334.39	(6,738.61)
Ажиллагсдын тоо	хүн	14.00	20.00	16.00	(4.00)
Нийт цалингийн сан	мян.төг	294,406.20	396,305.70	355,727.30	(40,578.40)
Нэг ажилтны сарын дундаж цалин	мян.төг	1,752.42	1,651.27	1,852.75	201.47
Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.16	1.15	1.05	(0.10)
<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>мян.төг</b>	<b>1,898,637.00</b>	<b>30,400.00</b>	<b>426.00</b>	<b>(29,974.00)</b>
Нийт авлага	мян.төг	2,878.70	-	25,663.90	25,663.90
Нийт өглөг	мян.төг	6,166,692.00	6,178,581.10	5,753,431.80	(425,149.30)
Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	2,725.50	14,614.60	13,397.30	(1,217.30)
Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	6,163,966.50	6,163,966.50	5,740,034.50	(423,932.00)

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,975.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 315.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 1,660.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 1,975.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 5,066.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.2 АЛБАН ШААРДЛАГА

**Илрүүлэлт 1:** Үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж байгаа ажилтанд 1,660.0 мянган төгрөгийн нутгийн дэмийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 12 дугаар сарын 18-ны "Нутгийн дэмийн хэмжээ, түүнийг олгох журамж батлах тухай" тогтоолын 4.4.4-т *"Хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр болон хөлсөөр ажиллаж буй ажилчдад нутгийн дэм олгохгүй"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д *"Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах"* тус тус гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

#### 3.3 ЗӨВЛӨМЖ

**Илрүүлэлт 1:** Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүн, Ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүн 315.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д *"Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм"* гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, хүчин төгөлдөр баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх зөвлөмж өгөв.

**Илрүүлэлт 2:** Няравын тайланд бараа материал худалдан авсан болон зарлагдсан зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт гарын үсэг, тамга дутуу байна. Мөн худалдан авалтын анхан шатны баримтын цахим хэлбэрийн бүрдүүлэлт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д *"Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно"*, 13.7-д *"Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж, баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүн, Ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүн 315.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	315.0					1	315.0				
Няравын тайланд бараа материал худалдан авсан болон зарлагдсан зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт гарын үсэг, тамга дутуу байна. Мөн худалдан авалтын анхан шатны баримтын цахим хэлбэрийн бүрдүүлэлт хангалтгүй.	1	-					1	-				
Үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж байгаа ажилтанд 1,660.0 мянган төгрөгийн нутгийн дэмийн нэмэгдэл олгосон байна.	1	1,660.0			1	1,660.0						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,975.0</b>			<b>1</b>	<b>1,660.0</b>	<b>2</b>	<b>315.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Тайлант оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 13,709.4 мянган төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй, 43,519.3 мянган төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	57,228.7			1	57,228.7		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>57,228.7</b>			<b>1</b>	<b>57,228.7</b>		